

..... оны сарын өдрийн Хоршооны бүх гишүүдийн хурлаар батлав.

“.....” ХОРШООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Хоршооны нэр

1.1. Хоршооны оноосон нэр: “.....”

2. Хоршооны байршил

2.1. Хоршоо нь аймгийн сумын (.-р) багийн нутаг дэвсгэрт байрлан үйл ажиллагаа явуулна.

Албаны телефон утас:

3. Хоршооны үүсгэн байгуулалт

3.1. Монгол Улсын Хоршооны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг үндэс болгон сайн дураараа нэгдэж, нээлттэй гишүүнчлэлтэйгээр (цаашид энэ дүрэмд "Хоршоо" гэнэ) байгуулав.

3.2. Хоршоог анх үүсгэн байгуулагчдын бүртгэлийг энэхүү дүрмийн салшгүй хэсэг болгож хавсаргав.

4. Хоршооны зорилго

4.1. Гишүүддээ үйлчлэх замаар тэдний орлогыг нэмэгдүүлэх, нийгэм, соёлын болон оюуны нийтлэг хэрэгцээг хангах явдал хоршооны зорилго мөн.

5. Хоршооны үйл ажиллагааны төрөл

5.1 Хоршоо дараахь төрлийн үйл ажиллагаа явуулна:

5.1.1. Гишүүдийнхээ мал аж ахуй, газар тариалан үйлдвэрлэлийг дэмжих

5.1.2. Мал аж ахуйн болон газар тариалангийн бүтээгдэхүүнийг бэлтгэн зах зээлд борлуулах ажлыг гишүүдтэй хамтран зохион байгуулах

5.1.3. Жижиг, дунд үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ

5.1.4. Гишүүдийн өрхийн аж ахуй эрхлэхэд зуучлан үйлчлэх

5.1.5. Гишүүдийнхээ эзэмшил бэлчээр, тариалангийн газар орчмын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, нөөц баялгийг зохистой ашиглах

6. Хоршооны үйл ажиллагаа явуулах хугацаа

6.1. Хоршоо хугацаагүй үйл ажиллагаа явуулна

Хоёр. Хоршооны үндсэн эрх, үүрэг, хариуцлага

7. Хоршооны үндсэн эрх

7.1. Хоршоо өөрийн үйл ажиллагааны агуулгыг илэрхийлсэн бэлгэдэл болон албан бичгийн хэвлэмэл уудас, өөрийн нэр бүхий тэмдэг хэрэглэнэ.

7.2. Хоршоо дүрэмдээ заасан зорилго, үйл ажиллагааг Монгол Улсын хуулийн хүрээнд бие даан буюу бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

7.3. Хоршоо дүрэмдээ заасан үйл ажиллагааны хүрээнд өөрөө шууд буюу харъяалах холбоо, хоршоо дундын байгууллагаар дамжуулан гадаад эдийн засгийн харилцаанд оролцож болно.

7.4. Хоршоо нь аж ахуйн үйл ажиллагаагаа хамтран явуулах, харилцан туслалцах зорилгоор нэг буюу хэд хэдэн дундын хоршоо байгуулах буюу тэдгээрт гишүүнээр элсэж болно.

- 7.5. Хоршоо нь ашиг сонирхлоо төрийн болон бусад байгууллага, түүнчлэн олон улсын холбогдох байгууллагад төлөөлүүлэх зорилгоор бусад хоршоодтой эвлэлдэн нэгдэж нэг буюу хэд хэдэн холбоо байгуулах буюу тэдгээрт элсэж болно.
- 7.6. Хоршоо өөрийн салбар, төлөөлөгчийн газартай байж болно.

8. Хоршооны үндсэн үүрэг

- 8.1. Хоршоо өөрийн үйл ажиллагаандаа олон улсын хоршооллын зарчмыг удирдлага болгон хоршооны гишүүд, тэдний гэр бүлийн болон оршин байгаа орчныхоо нийгмийн хөгжилд дэмжлэг үзүүлэн ажиллана.
- 8.2. Хоршооны тухай хууль, хоршооны дүрэм, хоршооны санхүүгийн тайлан тэнцэл, гишүүдийн бүртгэл зэрэг материалыг хоршоо өөр дээрээ байнга байлгаж, гишүүддээ саадгүй танилцуулж байна.

9. Хоршооны хариуцлага

- 9.1. Хоршоо нь үйл ажиллагааныхаа улмаас бий болсон үүргийг зөвхөн өөрийн эд хөрөнгөөр хариуцна.
- 9.2. Хоршооны эд хөрөнгө хүрэлцэхгүй тохиолдолд түүний үүргийг гишүүд нь нөхөж хариуцна. Гишүүдийн хүлээх нөхөх хариуцлагын хэмжээ нь нэг гишүүний заавал оруулах хувь хөрөнгийн 10 хувьтай тэнцүү байна.

Гурав. Хоршооны гишүүнчлэл

- 10.1. Хоршооны гишүүд Монгол Улсын Хоршооны тухай хуулийн дагуу хоршоог үүсгэн байгуулагч гишүүдийн жагсаалтад бүртгэгдсэн хүмүүс болон энэхүү дүрмийн 11-д заасны дагуу хоршоонд элссэн хүмүүс байна.
- 11.1. Нийгмийн гарал үүсэл, яс үндэс, хүйс, арьсны өнгө, нийгмийн байдал, улс төрийн үзэл бодол, шашин шүтлэгийн байдлаас хамааралгүйгээр дор дурдсан хүмүүс хоршоонд гишүүнээр элсэж болно:
- 11.1.1. Хоршооны энэхүү дүрмийг хүлээн зөвшөөрсөн, түүний үйлчилгээг ашиглаж, холбогдох хариуцлагыг хүлээх чадвартай иргэд;
- 11.1.2. Энэхүү дүрмийн 19-д заасны дагуу хөрөнгө өвлөгч;
- 11.2. Хоршоонд элсэхийг хүссэн иргэн өргөдлөө хоршооны Тэргүүлэгчдэд бичгээр гаргана.

12. Бүх гишүүдийн бүртгэл

- 12.1. Хоршооны бүх гишүүдийн бүртгэлийг Тэргүүлэгчид хөтлөж, хоршооны дарга хадгална.

13. Хоршооны гишүүний эрх

- 13.1. Хоршоо гишүүн хоёрын хоорондын харилцаа нь Монголын Улсын Хоршооны тухай хууль болон энэхүү дүрмийн заалтын дагуу зохицуулагдана.
- 13.2. Хоршооны гишүүн нь Хоршооны тухай хууль, болон бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийн дагуу дараахь эрхтэй:
- 13.2.1. Хоршооноос зохих үйлчилгээ авах;
- 13.2.2. Өөрийн хүсэлтээр гишүүнээс гарах, дахин элсэх;
- 13.2.3. Хоршооны үйл ажиллагаанд оролцох, Тэргүүлэгч болон Хяналтын зөвлөлийн гишүүнээр сонгох, сонгогдох, хоршооны хороодын гишүүнээр сонгогдох, томилогдох;
- 13.2.4. Бүх гишүүдийн хуралд оролцож асуулт тавих, мэдээлэл авах, санал гаргах, шийдвэр гаргахад таслах эрхтэй оролцох;

- 13.2.5. Нийлүүлсэн хувь хөрөнгийн хэмжээнээс үл хамааран саналын нэг эрх эдлэх;
- 13.2.6. Бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж шийдвэр гаргах асуудлаар хурал эхлэхээс 10- аас доошгүй хоногийн өмнө, шийдвэр гаргахгүйгээр хэлэлцэх асуудлаар 3-аас доошгүй хоногийн өмнө санал гаргах;
- 13.2.7. Бүх гишүүдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай санал гаргах;
- 13.2.8. Хоршооны жилийн орлогоос тогтоосон журмын дагуу хувь хүртэх;
- 13.2.9. Жилийн тайланг бүх гишүүдийн хурлаар батлахаас өмнө жилийн тайлан болон хяналтын зөвлөлийн дүгнэлтийг шаардан авах;
- 13.2.10. Бүх гишүүдийн хурлын тэмдэглэлтэй танилцах;
- 13.2.11. Хоршооны гишүүдийн бүртгэлтэй танилцах;
- 13.2.12. Хууль, журмын дагуу бусад гишүүдийн бүртгэлтэй танилцах;
- 13.2.13. Өрсөлдөгч бус хоршоонд гишүүнээр элсэх эсвэл өөр нэгэн аж ахуйн нэгжид хувь нийлүүлэх;
- 13.2.14. Хоршоо гишүүн хоёрын хооронд маргаантай асуудал гарсан тохиолдолд энэ талаар хоршооны Хяналтын зөвлөлд мэдэгдэнэ. Хяналтын зөвлөл шийдвэрлэж чадахгүй тохиолдолд бүх гишүүдийн хурлаар шийдвэрлүүлнэ.
- 13.2.15. Хууль, дүрэмд заасан бусад эрх.

14. Гишүүний үүрэг

- 14.1. Хоршооны гишүүн бүр дараахь үүрэгтэй:
 - 14.1.1. Хоршооныхоо ашиг сонирхлыг хамгаалах;
 - 14.1.2. Хоршоог байгуулах, үйл ажиллагаанд нь оролцох;
 - 14.1.3. Монгол Улсын Хоршооны тухай хууль болон хоршооны дүрэм, бүх гишүүдийн хурлын шийдвэрийг дагаж мөрдөх;
 - 14.1.4. Хоршоонд оруулах хувь хөрөнгөө хугацаанд нь бүрэн нийлүүлэх;
 - 14.1.5. Хоршооны болон бусад гишүүдийн өмнө гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх;
 - 14.1.6. Хаяг өөрчлөгдсөн нөхцөлд цаг тухайд нь хоршоондоо мэдэгдэх;
 - 14.1.7. Өөр хоршоонд гишүүнээр элссэн, эсвэл өөр аж ахуйн нэгжид хувь эзэмшиж буй тохиолдолд өөрийн хоршоонд цаг тухайд нь мэдэгдэх;
 - 14.1.8. Энэхүү дүрэмд заасан нөхөх хариуцлагыг хүлээх;
 - 14.1.9. Хоршооны гишүүдийн бүртгэлээс авсан мэдээллийн нууцыг чандлан хадгалах
 - 14.1.10. Хууль, дүрэмд заасан бусад үүрэг.

15. Хоршооны гишүүнээс гарах

- 15.1. Хоршооны гишүүнээс дараахь тохиолдолд гарна:
 - 15.1.1. Гишүүн өөрөө хүсэлт гаргасан;
 - 15.1.2. Гишүүн нь хоршооны оршин буй газраас өөр нутаг дэвсгэрт шилжсэнээр хоршооны үйл ажиллагаанд оролцох боломжгүй болсон;
 - 15.1.3. Гишүүн өөрт ногдох хувь хөрөнгөө бусдад бүхэлд нь шилжүүлсэн;
- 15.2. Хоршооны гишүүн нас барсан бол түүнийг гишүүнээс гарсанд тооцно.
- 15.3. Гишүүн хоршооноос гарах тухай хүсэлтээ хоршооны санхүүгийн жил дуусахаас 3-аас доошгүй сарын өмнө бичгээр гаргана.

16. Хоршооны гишүүнээс хасах

- 16.1. Хоршооны гишүүнээс дараахь үндэслэлээр бүх гишүүдийн хурлын шийдвэрээр хасна:
 - 16.1.1. Хоршооны гишүүн хууль, дүрэм, гэрээнд заасан үүргээ зөрчсөн;

- 16.1.2. Хоршооны гишүүнээс хасах тухай Тэргүүлэгчдийн сануулга авсны дараа уг зөрчлийг дахин гаргасан;
- 16.1.3. Өөрийн хоршоотой өрсөлдөх хоршоог өөрөө байгуулсан, эсвэл өрсөлдөгч хоршоонд хувь хөрөнгө нийлүүлсэн буюу түүнээс хувь хөрөнгө авч хоршоондоо нийлүүлсэн;
- 16.1.4. Хууль дүрэмд заасан бусад үндэслэлээр.
- 16.2. Гишүүнээс хасах тухай шийдвэр гаргахаас өмнө тухайн гишүүнд гишүүнээс хасах болсон үндэслэл, шалтгааныг бичгээр танилцуулах ба гишүүн үүнтэй холбогдуулан 30 хоногийн хугацаанд тайлбар хэлж болно.
- 16.3. Гишүүнээс хассан тухай шийдвэрт хасах болсон үндэслэл, шалтгааныг заана. Шийдвэрийг гишүүнд бичгээр өгнө.
- 16.4. Хоршооны гишүүнээс хассан тухай шийдвэр гарснаар уул гишүүний бүрэн эрх дуусгавар болно.
- 16.5. Хоршооны гишүүнээс хассан тухай шийдвэрийг тухайн этгээд эс зөвшөөрвөл гомдлоо 14 хоногийн дотор Хяналтын зөвлөлд гаргаж болно.
- 16.6. Хяналтын зөвлөлийн шийдвэрийг эс зөвшөөрсөн этгээд зохих журмын дагуу шүүхэд гомдол гаргана.

17. Гишүүнээс гарсан, хасагдсан этгээдтэй тооцоо хийх

- 17.1. Гишүүнээс гарсан, хасагдсан этгээдтэй холбогдох хууль тогтоомж, эрх зүйн бусад акт, энэ дүрмийг үндэслэн тооцоо хийнэ.
- 17.2. Гишүүн оруулсан бүх хөрөнгөө өөр гишүүнд шилжүүлсэн бол тухайн гишүүнтэй тооцоо хийх шаардлагагүй.
- 17.3. Харилцагч аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд хоршооноос төлөх төлбөрийн өөрт ногдох хэсгийг хоршооноос гарсан, хасагдсан этгээд энэ дүрэмд заасан журмаар бусад гишүүний нэгэн адил төлөх үүрэгтэй.
- 17.4. Хоршооны гишүүнээс гарсан, хасагдсан этгээдтэй тухайн жилийн эцсийн тайлан тэнцэл гарсны дараа эд хөрөнгийн тооцоо хийнэ.

18. Хоршоонд оруулсан хувь хөрөнгөө бусдад шилжүүлэх

- 18.1. Хоршооны гишүүн өөрийн оруулсан хувь хөрөнгийг бичгээр хийсэн гэрээний дагуу өөр гишүүнд хэдийд ч шилжүүлж болно.
- 18.2. Энэ дүрмийн 18.1 - д заасны дагуу гишүүний хувь хөрөнгийг шилжүүлэн авсан этгээдийн шилжүүлж авсан болон өөрийнх нь нийлүүлсэн хувь хөрөнгийн нийт хэмжээ нь нэг гишүүний оруулах хувь хөрөнгийн дээд хязгаараас илүүгүй байна.
- 18.3. Гишүүний хувь хөрөнгийг бүрэн хэмжээгээр шилжүүлсэн тохиолдолд гарсан гишүүнтэй тооцоо хийх шаардлагагүй..

19. Гишүүний эд хөрөнгийн эрх өв залгамжлагчид шилжих

- 19.1. Хоршооны гишүүн нас барсан бол түүний эд хөрөнгийн эрх өв залгамжлагчид шилжинэ.
- 19.2. Өв залгамжлагч нь 2 ба түүнээс дээш байвал гишүүнчлэлийн асуудлыг шийдвэрлэх хүртэл тэдгээр нь саналын нэг эрхтэй байна.
- 19.3. Өв залгамжлагчийг гишүүнд элсүүлэх асуудлыг Бүх гишүүдийн хурал шийдвэрлэнэ.

20. Аж ахуйн үйл ажиллагаанд хоршооны гишүүн бус этгээдийг оролцуулах нөхцөл, журам

- 20.1. Хоршоо аж ахуйн үйл ажиллагаандаа нягтлан бодогч, мал зүйч, агрономч зэрэг нарийн мэргэжлийн гишүүн бус этгээдийг хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр оролцуулж болно.

21. Гишүүнд үйлчлэх хэлбэр

- 21.1. Хоршоо гишүүддээ дараахь хэлбэрээр үйлчилнэ:
 - 21.1.1.Зээл олгох зэргээр өрхийн үйлдвэрлэл эрхлэхэд нь дэмжлэг үзүүлэх
 - 21.1.2. Технологийн тоног төхөрөөмж, техник хэрэгсэл, материал, түүхий эд олох, бүтээгдэхүүний борлуулах ажиллгаанд зуучлан үйлчлэх
 - 21.1.3.Мэдлэг боловсрол, техник, технологийн ур чадварыг дээшлүүлэх сургалт явуулах
 - 21.1.4.Хувийн үйлдвэрлэлээ хөгжүүлж, ашиг орлогоо нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх

Дөрөв. Хоршооны удирдлага

22. Хоршооны эрх барих байгууллага

- 22.1.Хоршоо дараахь эрх барих байгууллагатай байна:
 - 22.1.1.Бүх гишүүдийн хурал
 - 22.1.2.Хяналтын зөвлөл
 - 22.1.3.Тэргүүлэгчид

23. Бүх гишүүдийн хурал дээр гишүүд эрхээ хэрэгжүүлэх

- 23.1. Хоршооны эрх барих дээд байгууллага нь Бүх гишүүдийн хурал байна.
- 23.2. Хоршооны үйл ажиллагааны талаар шийдвэр гаргахад оролцох эрхээ гишүүд Бүх гишүүдийн хурал дээр хэрэгжүүлнэ.
- 23.3. Хоршооны гишүүн бүр саналын нэг эрхтэй.
- 23.4. Гишүүн саналын эрхээ Бүх гишүүдийн хуралд биеэр оролцох замаар хэрэгжүүлнэ.
- 23.5. Бүх гишүүдийн хуралд биечлэн оролцох боломжгүй болсон гишүүн нь зохих журмаар олгосон итгэмжлэл бүхий хууль ёсны төлөөлөгчөөр дамжуулан эрхээ хэрэгжүүлнэ.
- 23.6. Хэрэв гишүүн буюу төлөөлүүлж буй гишүүнтэй холбоотой асуудлаар хоршооноос хяналт шалгалт явуулах, эсвэл түүнийг ямар нэгэн ажил үүргээс нь чөлөөлөх шаардлага буй болсны улмаас энэ талаар шийдвэр гаргах болон түүнтэй эрх зүйн гэрээ байгуулахтай холбогдсон асуудлаар тухайн гишүүн санал хураалтад оролцохгүй.
- 23.7. Хэрэв хоёр ба түүнээс олон өвлөгч байвал гишүүнчлэлийн асуудал шийдэгдэх хүртэл тэдгээр нэг саналын нэг эрхтэй байна.

24. Бүх гишүүдийн хурлыг хуралдуулах хугацаа, хуралдах газар

- 24.1. Бүх гишүүдийн хурлыг жилд нэгээс доошгүй удаа хуралдуулна.
- 24.2. Бүх гишүүдийн ээлжит хурлыг тайлангийн жил дууссанаас хойш 4 сарын дотор хуралдуулна.
- 24.3. Хэрэв Тэргүүлэгчид болон Хяналтын зөвлөл өөр газрыг сонгож аваагүй бол Бүх гишүүдийн хурлыг хоршооны оршин байгаа газарт хийнэ.

25. Бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудал

- 25.1. Бүх гишүүдийн хурлын тов, хэлэлцэх асуудлыг 30-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд мэдэгдэнэ.
- 25.2. Бүх гишүүдийн хурлыг Тэргүүлэгчид зарлан хуралдуулна.
- 25.3. Бүх гишүүдийн хурлыг бэлтгэн явуулах ажлыг Тэргүүлэгчид эрхлэн гүйцэтгэнэ.
- 25.4. Хэрэв Тэргүүлэгчид энэхүү дүрэмд заасан үүргээ биелүүлэхгүй бол Хяналтын зөвлөл бүх гишүүдийн хурлын бэлтгэлийг хангаж, хурлыг зарлан хуралдуулна.

25.5. Энэхүү дүрмийн 25.2, 25.4 - д заасан шаардлагыг биелүүлээгүй Тэргүүлэгчид, Хяналтын зөвлөлийн гишүүдийг өөрчлөх эсэх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэхээр бүх гишүүдийн хурлыг яаралтай зарлан хуралдуулна.

25.6. Шийдвэр гаргахгүйгээр хэлэлцэх, мэдээлэх асуудлыг бүх гишүүдийн хурал эхлэхээс 3-аас доошгүй хоногийн өмнө төлөвлөгөөнд оруулан хэлэлцэж болно. Хурал удирдах, бүх гишүүдийн ээлжит бус хурал хуралдуулахтай холбогдсон асуудлаар шийдвэр гаргахад үл хамаарна.

25.7. Хуралд хэлэлцэхээр товлоогүй асуудлыг (хүндэтгэх шалтгаантайгаар оролцож чадаагүй гишүүдээс бусад) бүх гишүүн хуралд оролцож байгаа тохиолдолд тэдний дийлэнх олонхийн зөвшөөрснөөр хэлэлцэнэ.

26. Бүх гишүүдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлаар хэлэлцэх асуудал

26.1. Бүх гишүүдийн ээлжит бус хурлыг гишүүдийн 1/3-ээс доошгүй хувийн саналаар зарлан хуралдуулж болно. Тухай саналаа гишүүд бичгээр гаргаж гарын үсгээ зурах ба түүнд бүх гишүүдийн ээлжит бус хурлыг хуралдуулах үндэслэл, шалтгааныг заана.

26.2. Энэ дүрмийн 26.1 заалтыг хэрэгжүүлэх тохиолдолд тэргүүлэгчид ээлжит бус бүх гишүүдийн хурлыг хуралдуулах үндэслэл, шалтгаан, хэлэлцэх асуудлын талаар гишүүдэд мэдэгдэнэ.

26.3. Хэрэв тэргүүлэгчид энэхүү дүрмийн 26.2-т заасан үүргээ биелүүлэхгүй бол хяналтын зөвлөл бүх гишүүдийн ээлжит бус хурлын бэлтгэлийг хангаж, хурлыг зарлан хуралдуулна.

27. Бүх гишүүдийн хурлыг удирдах

27.1. Бүх гишүүдийн хурлыг хоршооны дарга удирдаж, шийдвэрт нь гарын үсэг зурна. Түүнийг байхгүй үед Хяналтын зөвлөлийн дарга буюу түүний орлогч, эсхүл хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар сонгогдсон хоршооны өөр нэг гишүүн даргалж, шийдвэрт нь гарын үсэг зурна.

27.2. Хурлын нарийн бичгийн дарга болон тооллогын комиссын гишүүдийг гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

28. Бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэх асуудал

28.1. Дор дурдсан асуудлыг бүх гишүүдийн хурлаар шийдвэрлэнэ:

28.1.1. дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;

28.1.2. тэргүүлэгч болон Хяналтын зөвлөлийн гишүүдийг сонгох, чөлөөлөх, огцруулах, тэдгээрийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэж, үнэлэлт дүгнэлт өгөх;

28.1.3. тэргүүлэгч болон Хяналтын зөвлөлийн гишүүдийг хоршооноос хасах;

28.1.4. тэргүүлэгч болон Хяналтын зөвлөлийн буруутай үйл ажиллагааны улмаас хоршоонд учирсан хохирлыг буруутай эзнээр нөхөн төлүүлэх;

28.1.5. хоршооны хөрөнгийг захиран зарцуулах нөхцөл, журмыг тогтоох;

28.1.6. Гишүүнээс нийлүүлсэн хувь хөрөнгийг буцааж олгох журам, зээл авах болон зээл олгох хязгаарлалтыг тогтоох;

28.1.7. хоршооны гишүүний элсэлтийн татварын хэмжээг тогтоох;

28.1.8. жилийн тайлан тэнцлийг батлах, тухайн жилийн цэвэр орлогыг хуваарилах, алдагдалтай ажилласан бол түүнийг нөхөх хэлбэрийг тогтоох, Хоршоодын холбоо болон Хяналтын зөвлөлийн шалгалтын дүнг хэлэлцэх, хоршооны жилийн зардлын төсөв батлах;

28.1.9. дундын хоршоо байгуулах буюу тэдгээрт гишүүнээр элсэх, хоршоодын холбоонд эвлэлдэн нэгдэх;

28.1.10. хоршоо аж ахуйн нэгжийн хэлбэрээ өөрчлөх;

- 28.1.11. хоршоог татан буулгах;
- 28.1.12. хоршоо нэг буюу хэд хэдэн хоршоотой нэгдэх;
- 28.1.13. хоршоо хоёр буюу түүнээс олон хоршоо болж өөрчлөгдөх;
- 28.1.14. хоршооны үйл ажиллагаа явуулах хугацааг өөрчлөх;
- 28.1.15. хоршооны салбар болон төлөөлөгчийн газар байгуулах;
- 28.1.16. хоршоо гүйцэтгэх захиралтай байх эсэх;
- 28.1.17. хоршооны үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөх;
- 28.1.18. гишүүнээс хоршоонд заавал оруулах хувь хэмжээг өөрчлөх;
- 28.1.19. хоршооны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг тодорхой хэмжээгээр завал хэрэглэж байхыг гишүүдэд үүрэг болгох;
- 28.1.20. гишүүний нөхөх хариуцлагын хэмжээг өөрчлөх;
- 28.1.21. тэргүүлэгч, Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг хүлээн зөвшөөрөх;
- 28.1.22. Бүх гишүүдийн хурлын оронд төлөөлөгчдийн хурлыг бий болгох, төлөөлөгчдийн хурлын гишүүдийн тоо, сонгуулийн журмыг тогтоох шийдвэр гаргах;
- 28.1.23. гишүүдээс санал болгосон бусад асуудал;
- 28.1.24. хууль, дүрэмд заасан бусад асуудал.
- 29.1. Бүх гишүүдийн хурал гишүүдийн дийлэнх олонхи (66,6%) оролцсоноор хүчин төгөлдөр болно.
- 29.2. Бүх гишүүдийн хурлын шийдвэрийг энэхүү дүрэмд тухайлан зааснаас бусад тохиолдолд хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гаргана.
- 29.3. Дараахь асуудлыг хуралд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн (66,6%) саналаар шийдвэрлэнэ :
 - 29.3.1. дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах ;
 - 29.3.2. тэргүүлэгчид болон хяналтын зөвлөлийг сонгох,чөлөөлөх, огцруулах, тэдгээрийн жилийн тайланд үнэлэлт дүгнэлт өгөх;
 - 29.3.3. тэргүүлэгчид болон хяналтын зөвлөлийн ажиллах журмыг батлах.
- 29.4. Дараахь тохиолдолд бүх гишүүдийн 3/4-аас доошгүйн саналаар асуудлыг шийдвэрлэнэ:
 - 29.4.1. хоршооны үйл ажиллагааны төрлийг өөрчлөх;
 - 29.4.2. гишүүдээс хоршоонд заавал оруулах хувь хөрөнгийн хэмжээг өөрчлөн тогтоох;
 - 29.4.3. гишүүдийн нөхөх хариуцлагын хэмжээг өөрчлөн тогтоох;
 - 29.4.4. хоршоо нэг буюу хэд хэдэн хоршоотой нэгдэх;
 - 29.4.5. хоршоо хоёр буюу түүнээс олон хоршоо болж өөрчлөгдөх;
 - 29.4.6. хоршоог татан буулгах;
 - 29.4.7. хоршооны бараа бүтээгдэхүүн худалдан авах, нийлүүлэх, байгууламж, тоног төхөөрөмжийг ашиглах, хоршооны үйлчилгээ авах асуудлаар гишүүдэд үүрэг хүлээлгэх;
 - 29.4.8. хоршооны үйл ажиллагаа явуулах хугацааг өөрчлөн тогтоох;
- 30. Бүх гишүүдийн хурал дахь сонгууль, санал хураалт**
 - 30.1. Бүх гишүүдийн хурал дээр санал хураалт, сонгуулийг нууцаар явуулна.
 - 30.2. Санал тэнцсэн тохиолдолд тухайн асуудлаар дахин санал хураалт явуулна.
- 31. Бүх гишүүдийн хурал дээр гишүүд мэдээлэл авах эрх**
 - 31.1. Бүх гишүүдийн хурал дээр хэлэлцэж байгаа асуудлаар хоршооны гишүүнээс ажил хэрэгч дүгнэлт гаргах зорилгоор хоршооны үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар тавьсан асуултад Тэргүүлэгчид хариулт өгөх үүрэгтэй.

31.2. Гишүүний тавьсан хоршооны ашиг сонирхолд харш асуултад Тэргүүлэгчид тодорхой үндэслэл, шалтгааныг дурдаж, хариу өгөхөөс татгалзаж болно.

32. Хоршооны Тэргүүлэгчид

32.1. Тэргүүлэгчид нь-аас доошгүй сондгой тоотой байх тэргүүлэгчдийн дарга нь хоршооны дарга байна.

32.2. Тэргүүлэгчдийн дарга болон бусад гишүүдийг бүх гишүүдийн хуралд оролцогч гишүүдийн дийлэнх олонхийн саналаар жилийн хугацаагаар сонгоно. Тэргүүлэгчид нь тус хоршооны гишүүн байна.

32.3. Тэргүүлэгч гишүүнийг дахин сонгож болно.

32.4. Бүх гишүүдийн хурлын дийлэнх олонхийн саналаар Тэргүүлэгч гишүүнийг чөлөөлж, огцруулна.

32.5. Тэргүүлэгчид 2 сард нэгээс доошгүй удаа хуралдана.

32.6. Тэргүүлэгчдийн ажиллах журмыг бүх гишүүдийн дийлэнх олонхийн саналаар батална.

33. Тэргүүлэгчдийн бүрэн эрх

33.1. Бүх гишүүдийн хурлын чөлөөт цагт хоршооны үйл ажиллагааг Тэргүүлэгчид удирдана.

33.2. Тэргүүлэгчид хоршоог төлөөлнө.

33.3. Тэргүүлэгчид хоршоог төлөөлөх эрхийг тэдгээрийн олонхийн саналаар хэрэгжүүлнэ.

33.4. Тэргүүлэгчид үйл ажиллагааныхаа талаар бүх гишүүдийн хуралд тайлагнаж, хариуцлага хүлээнэ.

33.5. Тэргүүлэгчид хоршоог хөгжүүлэх бодлого, стратеги болон бизнес төлөвлөгөө боловсруулж, бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулна.

33.6. Тэргүүлэгчид хоршооны тухайн жилийн төсөв ба үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлж батлуулна.

33.7. Тэргүүлэгчид хоршооны тайлан тэнцэл, жилийн ажлын тайлан болон орлого хуваарилах буюу алдагдлыг нөхөх тухай саналаа Хяналтын зөвлөлийн дүгнэлтийн хамт бүх гишүүдийн хуралд оруулж хэлэлцүүлнэ.

33.8. Тэргүүлэгчид хоршооны тайлан тэнцэл, жилийн ажлын тайлан болон орлого хуваарилах буюу алдагдлыг нөхөх тухай саналаа Хяналтын зөвлөлийн дүгнэлтийн хамт бүх гишүүдийн хуралд оруулж хэлэлцүүлнэ.

33.9. Жилийн болон завсрын тайлан гаргахад, эсхүл баримжаалсан тооцоогоор алдагдал гарч, тэр нь хоршооны эд хөрөнгийн нийт дүнгийн 50 хувьд хүрсэн болон нөөцийн сангийн хөрөнгөөс нөхөж чадахгүйд хүрвэл Тэргүүлэгчид бүх гишүүдийн хурлыг нэн даруй зарлан хуралдуулж, уг асуудлыг хэлэлцүүлэх үүрэгтэй.

33.10. Тэргүүлэгчид хоршооны гишүүдийн бүртгэл хөтлөнө.

33.11. Хоршооны дүрэм баталснаас хойш 30 хоногийн дотор Тэргүүлэгчид харъяалах нутаг дэвсгэрийн бүртгэх байгууллагад хоршоог бүртгүүлэх өргөдөл гаргана.

33.12. Хоршооны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай бүх гишүүдийн хурлын шийдвэр гарснаас хойш Тэргүүлэгчид 10 хоногийн дотор бүртгэх байгууллагад мэдэгдэнэ.

34. Тэргүүлэгчдийн хариуцлага

34.1. Тэргүүлэгчид бүх гишүүдийн хурлын өмнө хамтын хариуцлага хүлээнэ.

34.2. Тэргүүлэгчид хоршооны бизнесийн нууцад хамаарах мэдээллийг чандлан хадгална.

34.3. Тэргүүлэгч гишүүд хууль, дүрэм зөрчиж дараах зөрчил гаргасан тохиолдолд түүнээс учирсан хохирлыг нөхөн төлнө:

34.3.1. Хоршооны гишүүдэд оногдох хувь болон орлогоос ашигласан, захиран зарцуулсан;

- 34.3.2. Хоршооны хөрөнгөөр төлбөр хийсэн;
- 34.3.3. Хоршоог төлбөрийн чадваргүй болгосон буюу дампууруулах үндэслэл бүрдүүлсэн;
- 34.3.4. Хоршооны хөрөнгөөс зээл олгосон;
- 34.4. Бүх гишүүдийн хурлын шийдвэрээр явуулсан үйл ажиллагааны улмаас учирсан хохирлыг Тэргүүлэгчид нөхөн төлөхгүй.

35. Хяналтын зөвлөл

- 35.1. Хяналтын зөвлөлийг бүх гишүүдийн хурлаас жилийн хугацаагаар сонгоно. Хяналтын зөвлөлийн гишүүд нь тус хоршооны гишүүн байна.
- 35.2. Хяналтын зөвлөл- аас доошгүй гишүүнтэй байна.
- 35.3. Хяналтын зөвлөлийн гишүүд дундаасаа дарга, орлогч даргыг сонгоно.
- 35.4. Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны журмыг бүх гишүүдийн хурлын дийлэнх олонхийн саналаар батлана.

36. Хяналтын зөвлөлийн гишүүн

- 36.1. Хяналтын зөвлөлийн гишүүд Тэргүүлэгчдийн хуралд зөвлөх эрхтэй оролцоно.
- 36.2. Хяналтын зөвлөлийн гишүүн нь тэргүүлэгчээр сонгогдож үл болно.
- 36.3. Хяналтын зөвлөлийн гишүүний үндсэн үүргээ гүйцэтгэхтэй холбогдон гарсан зардлыг хоршооноос нөхөн олгох ба түүнд бүх гишүүдийн хурлын шийдвэрийн дагуу зохих урамшил олгож болно.
- 36.4. Хяналтын зөвлөлийн гишүүд үүрэгт ажлаа гүйцэтгэх явцад олж мэдсэн хоршооны үйл ажиллагаа болон гишүүд, тэрчлэн түншүүдийн талаархи мэдээллийн нууцыг чандлан хадгалах үүрэгтэй.

37. Хяналтын зөвлөлийн хуралдаан

- 37.1. Хяналтын зөвлөлийн хуралдааныг дарга, түүний байхгүйд орлогч дарга зарлан хуралдуулна.
- 37.2. Гишүүдийн олонхи оролцсоноор хуралдааныг хүчин төгөлдөр гэж үзнэ.
- 37.3. Хуралдааныг зөвхөн дарга, эсхүл түүний орлогч удирдана.
- 37.4. Хяналтын зөвлөл улиралд 1-ээс доошгүй удаа хуралдана.
- 37.5. Хоршооны Тэргүүлэгчид, эсхүл Хяналтын зөвлөлийн гишүүдийн 50-иас дээш хувь нь Хяналтын зөвлөлийг хуралдуулахыг шаардсан, эсхүл Хяналтын зөвлөлийн дарга шаардлагатай гэж үзсэн бол ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулна.

38. Хяналтын зөвлөлийн бүрэн эрх

- 38.1. Хяналтын зөвлөл дотоодын хяналтыг хэрэгжүүлж, дараахь бүрэн эрхийг эдлэнэ:
 - 38.1.1. Тэргүүлэгчдийн үйл ажиллагааг хянан шалгах, үүний тулд шаардлагатай баримт бичгийг гаргуулан авах, Тэргүүлэгчдийн мэдээлэл, илтгэл сонсох, нягтлан бодох бүртгэл, бусад бичиг баримттай танилцаж шалгах;
 - 38.1.2. хоршооны жилийн тайлан, цаг үеийн байдлын тухай мэдээ, жилийн орлогын хуваарилалт, алдагдлыг хэрхэн нөхөх асуудлаар санал дүгнэлт гаргаж, бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх;
 - 38.1.3. шаардлагатай гэж үзвэл бүх гишүүдийн хурлыг зарлан хуралдуулах;
 - 38.1.4. хууль тогтоомж болон хоршооны дүрэм, бүх гишүүдийн хурлаас баталсан журмын дагуу Тэргүүлэгчдэд зээл олгох асуудлыг шийдвэрлэх;
 - 38.1.5. хууль дүрэмд заасан бусад бүрэн эрх.
- 38.2. Хяналтын зөвлөл шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн шинжээчийг төлбөртэй ажиллуулж болно.

- 38.3. Хоршооны санхүү, хөрөнгөд тогтмол болон гэнэтийн шалгалт, тооллого хийнэ.
- 38.4. Хяналтын зөвлөл өөрийн үйл ажиллагааны тухай бүх гишүүдийн хуралд тайлагнаж хариуцлага хүлээнэ.
- 38.5. Хяналтын зөвлөл нь гаднын шалгалтын байгууллагын дүгнэлтийн хэрэгжилтийг хариуцах үүрэгтэй.

39. Хоршооны дарга

- 39.1. Хоршооны даргыг бүх гишүүдийн хурлаас сонгоно.
- 39.2. Хоршооны дарга бүх гишүүдийн болон Тэргүүлэгчдийн хурлыг удирдаж, шийдвэрт нь гарын үсэг зурна. Түүний эзгүйд тэргүүлэгчдийн аль нэг нь Тэргүүлэгчдийн хурлыг удирдана.
- 39.3. Хоршооны дарга хоршоог төлөөлөх итгэмжлэлд гарын үсэг зурна.

40. Хоршооны гүйцэтгэх захирал

- 40.1. Хоршоо гүйцэтгэх захиралгүйгээр үйл ажиллагаа явуулна.

41. Хоршооны хороод

- 41.1. Тэргүүлэгчид шаардлагатай гэж үзвэл хоршоо нэг буюу хэд хэдэн хороотой байж болно.
- 41.2. Хоршооны хорооны гишүүдийг хуульд өөрөөр заагаагүй бол Тэргүүлэгчид томилно.
- 41.3. Хорооны ажиллах журмыг Тэргүүлэгчид тогтооно.
- 41.4. Хорооны гишүүд үүрэгт ажлаа гүйцэтгэх явцад олж мэдсэн мэдээллийн нууцыг хадгалах үүрэгтэй.

Тав. Хоршооны хөрөнгө

42. Хоршооны хөрөнгийн эх үүсвэр

- 42.1. Хоршооны хөрөнгө дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:
- 42.1.1. гишүүдээс нийлүүсэн хувь хөрөнгө;
- 42.1.2. гишүүдийн элсэлтийн татвар;
- 42.1.3. хоршооны үйл ажиллагааны орлогоос болзошгүй алдагдлын нөөцийн санд хуваарилсан хөрөнгө;
- 42.1.4. бэлэглэсэн, хандивласан хөрөнгө.
- 42.1.5. хоршооны өмчлөл дахь бусад хөрөнгө нь хоршооны үйл ажиллагааны явцад авсан зээл болон бусад эх үүсвэрээс бий болсон учир түүнийг хоршоо тарах, татан буугдах хүртэл гишүүдэд хуваарилан давхар бүртгэхгүй.
- 42.2. Хоршооны эд хөрөнгө нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжид зааснаар бүртгэлтэй байх бөгөөд түүнийг гишүүн тус бүрийн нэр дээр хуваарилан дараахь байдлаар давхар бүртгэнэ:
- 42.2.1. гишүүний нийлүүлсэн хувь хөрөнгийг үнийн дүнгээр болон биет байдлаар;
- 42.2.2. хоршооны болзошгүй алдагдлын нөөц санд үлдээхээр хуваарилсан хөрөнгийг гишүүдэд орлого хуваарилах журмаар тооцсон үнийн дүнгээр;
- 42.2.3. бэлэглэсэн, хандивласан хөрөнгийг гишүүдэд тэнцүү хуваасан үнийн дүнгээр.

43. Гишүүний хувь хөрөнгө, элсэлтийн татвар

- 43.1. Хоршоонд гишүүнээр элссэнээр гишүүн нь хоршооны эд хөрөнгийн зохих хувийн өмчлөгч болж, хоршооны гишүүний эрх, үүрэг үүснэ;
- 43.2. Гишүүн бүр хоршоонд-..... төгрөгийн хувь хөрөнгө заавал оруулна.
- 43.3. Гишүүн бүр хоршоонд заавал нийлүүлэх хувь хөрөнгийг шууд нийлүүлнэ.

- 43.4. Нэг гишүүний хоршоонд оруулж болох нэмэлт хувь хөрөнгийн хэмжээ нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн **20 /хорин/** хувиас хэтэрч болохгүй.
- 43.5. Гишүүний нийлүүлсэн хувь хөрөнгийн нийт дүн нь хоршооны хөрөнгөөс түүнд оногдох хэмжээг тодорхойлно.
- 43.6. Хоршооны эд хөрөнгөөс гишүүнд оногдох хэмжээ нь гишүүний нийлүүлсэн нийт хувь хөрөнгө (заавал оруулах хувь хөрөнгө, нэмж оруулсан хувь хөрөнгө, хөдөлмөр оролцоо) хоршооны жил бүрийн цэвэр орлогоос ногдох хэмжээгээр нэмэгдэж, алдагдлаас ногдох хэмжээгээр хорогдоно.
- 43.9. Хоршооны гишүүн хэвээр байгаа тохиолдолд хоршоо гишүүнд оногдож байгаа хувь хөрөнгөөр гүйлгээ хийх буюу хоршооны үйл ажиллагааны баталгаа болгон хэрэглэж болно. Гишүүн өөрт оногдож байгаа хөрөнгийг бусадтай харилцах харилцаанд баталгаа болгон хэрэглэж болохгүй.
- 43.10. Гишүүнээс хоршоонд заавал нийлүүлэх хувь хөрөнгө болон ажил үйлчилгээ нь бэлэн мөнгө, биет хөрөнгө, ажил үйлчилгээ болон оюуны өмчийн хэлбэртэй байж болно.
- 43.11. Гишүүнээс хоршоонд хувь нийлүүлсэн биет хөрөнгө болон ажил үйлчилгээг тухайн орон нутгийн тэр үеийн зах зээлийн үнээр үнэлнэ. Үнэлгээг Тэргүүлэгчдээс байгуулсан комисс хийнэ.
- 43.12. Гишүүнээс хоршоонд нийлүүлсэн хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө хоршооны эзэмшилд шилжинэ.
- 43.13. Хоршооны гишүүнд элсэхэд татвартай байх ба элсэлтийн татвар нь төгрөг байна.

44. Хоршооны нөөцийн болон бусад сан

- 44.1. Хоршооны жил бүрийн цэвэр орлогоос **20** хувийг болзошгүй алдагдлын нөөцийн санд хуваарилна. Бүх гишүүдийн хурал нь хувийг өөрчлөн тогтоож болно.
- 44.2. Хоршооны болзошгүй алдагдлын нөөцийн санд байнга байлгах хөрөнгийн хэмжээг бүх гишүүдийн хурал тогтооно.
- 44.3. Хоршооны болзошгүй алдагдлын нөөцийн сан нь жилийн эцсийн тайлан тэнцлээр гарах алдагдлыг нөхөх зориулалттай байна. Хоршооны болзошгүй алдагдлын нөөцийн сангийн хөрөнгийг хоршоо үйл ажиллагаагаа зогсоох хүртэлх хугацаанд гишүүдэд хуваарилахгүй.
- 44.4. Энэ дүрмийн 44.1-д заасан гишүүний элсэлтийн татварыг болзошгүй алдагдлын нөөц санд оруулна.
- 44.5. Хоршоо өөр төрлийн сан байгуулж болно. Бүх гишүүдийн хурал өөр төрлийн санг байгуулах эсэх, тэдгээрийн хэмжээ, ашиглалтын тухай шийдвэрийг гаргана.

45. Зээл авах, олгох журам

- 46.1. Бүх гишүүдийн хурлын зөвшөөрлөөр хоршооны Тэргүүлэгчид хоршооны үйл ажиллагаанд зориулан өөрийн хоршооны гишүүд болон улсын бүртгэлтэй байгууллагаас зээл авч болно.
- 46.2. Эдгээр зээлийг зөвхөн Бүх гишүүдийн хурлаас зөвшөөрсөн үйл ажиллагаанд зарцуулна.
- 46.3. Хоршооны дарга зээлийн ашиглалт, төлбөрийн талаар бусад тэргүүлэгчид болон Хяналтын зөвлөлд улирал тутам мэдээлэх үүрэгтэй.
- 46.4. Хоршооны бүх гишүүдийн хурлаас тогтоосон журам, хууль, дүрмийн дагуу Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрээр улсын бүртгэлтэй бусад хоршоод, аж ахуйн нэгж болон ТББ-дад зээл олгож болно.

47. Хоршооны хөрөнгө оруулалт

47.1. Хоршооны бүх гишүүдийн хурлын шийдвэрээр тогтоосон хэмжээ, журмын дагуу хоршоо нөөцийн болон бусад сангаас дараахь чиглэлээр хөрөнгө оруулалт хийж болно:

47.1.1. өөрийн үйлдвэрлэл, үйлчилгээг шинэчлэх, өргөтгөх;

47.1.2. улсын бүртгэлтэй хоршоо, нэгдэн орсон дундын хоршоо, хоршоодын холбоонд хувь нийлүүлэх;

47.1.3. улсын бүртгэл бүхий банк, санхүүгийн байгууллагад хувь нийлүүлэх;

47.1.4. Бүх гишүүдийн хурлаас зөвшөөрсөн бусад зориулалтаар;

47.2. хоршооны үл хөдлөх хөрөнгийг борлуулсны үнийн зөрүүг болзошгүй алдагдлын нөөцийн санд бүртгэнэ.

48. Хоршооны тайлангийн жил

48.1. Хоршооны тайлангийн жилийг хоршоо анх байгуулагдаж, улсын бүртгэлд бүртгүүлсэн өдрөөс тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдрөөр тооцно.

48.2. Цаашид жил бүрийн 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31-ний өдрөөр тооцно.

49. Хоршооны бүртгэл тооцоо

49.1. Тэргүүлэгчид хоршооны бүртгэл тооцоог Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, санхүүгийн төв байгууллагаас олон улсын стандартад нийцүүлэн баталж гаргасан нягтлан бодохын ба анхан шатны бүртгэлийн журам, зааврын дагуу хөтлүүлж, түүнд орлого, зарлагыг бүрэн тусгаж, хоршооны санхүү, эдийн засгийн үзүүлэлтийг бүрэн тодорхойлсон байна.

49.2. Тэргүүлэгчид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу цэвэр орлого буюу алдагдлыг тодорхойлсон тайлан тэнцэл гаргана.

50. Хоршооны цэвэр орлого ба алдагдал

50.1. Хоршооны цэвэр орлого буюу алдагдал нь нийт орлогоос нийт зардлыг хассанаар тодорхойлогдоно. Энэхүү дүрмийн 52.1.-д заасан гишүүдэд олгосон үнийн зөрүү болон энэ дүрмийн 45.1-д заасан болзошгүй алдагдлын нөөц санд хуваарилсан хөрөнгө нийт зардалд багтана.

50.2. Хоршооны цэвэр орлого тогтоогдмогц Тэргүүлэгчид энэхүү дүрмийн 45.1 дагуу хоршооны нөөц санд хуваарилах хөрөнгийн хэмжээ болон энэ дүрмийн 52.1 ийн дагуу хоршооны үйлчилгээг ашигласан гишүүдийн оролцоонд харьцуулан гишүүдэд олгох үнийн зөрүүг тооцож санал боловсруулна.

51. Хоршооны цэвэр орлогыг хуваарилах, алдагдлыг нөхөх

51.1. Гишүүдэд үнийн зөрүү хуваарилсны дараахь цэвэр орлогыг Тэргүүлэгчид дор дурдсан чиглэлээр хуваарилах талаар санал боловсруулна:

51.1.1. хоршооны бусад санд хуваарилах;

51.1.2. гишүүн бүрийн оруулсан хувь хөрөнгө, хөдөлмөр оролцоо зэрэгт ногдох орлого хуваарилах.

51.2. Хоршоо алдагдалтай ажилласан бол Тэргүүлэгчид алдагдлыг дараахь эх үүсвэрээс нөхөх санал гаргана:

51.2.1. хоршооны болзошгүй алдагдлын нөөцийн сангаас;

51.2.2. энэ дүрмийн 45.5 –д заасан хоршооны бусад сангаас;

51.2.3. гишүүн бүрийн хувь хөрөнгөд ногдох хэмжээгээр;

51.2.4. гишүүдийн нөхөх хариуцлагаас.

51.3. Тэргүүлэгчид нь болзошгүй алдагдлын нөөц санд хуваарилах хөрөнгийн хэмжээ гишүүдэд хуваарилах орлого, үнийн зөрүүгийн хэмжээ ба алдагдлыг нөхөх талаархи саналаа Хяналтын зөвлөлд оруулна. Хяналтын зөвлөл үүнийг шалгаж санал нэгтэй тохиолдолд бүх гишүүдийн хуралд оруулна.

51.4. Бүх гишүүдийн хурал дүрэмд заасан журмын дагуу орлогыг хуваарилах ба алдагдлыг нөхөх асуудлыг хэлэлцэж, санал хурааж, шийдвэр гаргана.

52. Гишүүдэд үнийн зөрүү хуваарилах

52.1. Хоршооны үйл ажиллагааны үр дүнд буй болсон үнийн зөрүүг хоршооны үйлчилгээг ашигласан гишүүний оролцоогоор хуваарилна.

52.2. Хоршооны ажил үйлчилгээ, нийлүүлэлтээс гишүүнд ногдох үнийн зөрүүг дараа тооцох хэлбэрээр урьдчилан олгож болно.

52.3. Гишүүн бүрт ногдох үнийн зөрүүг Тэргүүлэгчид тооцох бөгөөд Хяналтын зөвлөл түүнийг хянана.

53. Гишүүдэд ногдол орлого хуваарилах

53.1. Бүх гишүүдийн хурал тайлангийн жил дууссанаас хойш 4 сарын дотор хоршооны цэвэр орлогыг гишүүдэд ногдол орлогын хэлбэрээр хуваарилна.

54. Салбар буюу төлөөлөгчийн газрууд

54.1. Гишүүдээ дэмжих үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор хоршоо нь өөрийн нэг ба хэд хэдэн салбар буюу төлөөлөгчийн газар нээж болно.

54.2. Салбар буюу төлөөлөгчийн газар нээх саналыг хоршооны гишүүд, тэргүүлэгчид хэн нь ч гаргаж болно.

54.3. Салбар буюу төлөөлөгчийн газар нээх асуудлыг бүх гишүүдийн хурлаар элэлцэж хуралд оролцогч гишүүдийн 3/4-ын саналаар шийдвэрлэнэ.

54.4. Салбар, төлөөлөгчийн газрын эрх, үүрэг, хариуцлагыг бүх гишүүдийн хурлаас тогтооно.

Зургаа. Хоршоодын холбоонд нэгдэх, хоршоодын холбооноос тавих хяналт

55. Хоршоодын холбоон дахь гишүүнчлэл

55.1. Гишүүдээ дэмжих үйл ажиллагаагаа сайжруулах зорилгоор хоршоо нь хоршоодын холбоотой хамтран ажиллана.

55.2. Бүх гишүүдийн хурал Тэргүүлэгчдийн оруулсан саналыг хэлэлцэж, хоршоо аль холбоонд элсэх талаар шийдвэр гаргана.

55.3. Хоршоо, хоршоодын холбоо хоорондын харилцааны эрх зүйн асуудлыг холбогдох хууль тогтоомж болон хоршоодын холбооны дүрмийн заалтаар зохицуулна.

55.4. Тэргүүлэгчдийн саналаар хоршоодын холбооноос гарах, эсвэл өөр холбоонд элсэх асуудлыг бүх гишүүдийн хурлаас шийдвэрлэнэ.

56. Хоршоодын холбооноос тавих хяналт

56.1. Хоршоодын холбоо нь өөрийн гишүүн хоршоонд хөндлөнгийн хяналт шалгалт хийнэ. Хоршоодын холбоо нь хоршооны удирдлага, зохион байгуулалтын бүтэц болон хоршооны эд хөрөнгийг хууль зүйн дагуу, зориулалтаар нь захиран зарцуулж байгаа эсэхийг хянан шалгана.

56.2. Хоршоодын холбооноос гүйцэтгэх хөндлөнгийн хяналт шалгалтыг дараахь тохиолдолд хийнэ:

- 56.2.1. хоршоодын холбооны дүрмийн үндсэн дээр хоршооны жилийн эцсийн тайлангийн ээлжит шалгалт;
- 56.2.2. ээлжит бус шалгалтыг хоршооны Тэргүүлэгчид, Хяналтын зөвлөл, эсвэл бүх гишүүдийн хурлын хүсэлтээр хийж болно;
- 56.2.3. ээлжит бус шалгалтыг тухайн холбооны дүрмийн дагуу хийнэ.
- 56.3. Тэргүүлэгчид шалгалтанд шаардагдах бичиг баримт, мэдээллийг хоршоодын холбооны шалгагчдад гаргаж өгөх үүрэгтэй.
- 56.4. Хоршооны Тэргүүлэгчид болон Хяналтын зөвлөл хяналт шалгалтын дүнг хамтарсан хуралдаанаараа хэлэлцэж, шаардагдах арга хэмжээнүүдийг авна.
- 56.5. Тэргүүлэгчид нь хяналт шалгалтын дүнг Тэргүүлэгчид, Хяналтын зөвлөлийн хамтарсан хуралдаанаар хэлэлцсэн шийдвэрийн хамт дараагийн бүх гишүүдийн хуралд оруулж танилцуулна.
- 56.6. Бүх гишүүдийн хурал хяналт шалгалтын дүнг хэлэлцэж шаардагдах арга хэмжээнүүдийг авна.

Долоо. Хоршоог татан буулгах

57. Хоршоог бүх гишүүдийн хурлын шийдвэрээр татан буулгах

- 57.1. Хоршоог бүх гишүүдийн хурлын шийдвэрээр татан буулгаж болно.
- 57.2. Хоршоог татан буулгах тухай асуудлыг санал хураалтад оролцсон гишүүдийн 3/4-аас доошгүйн саналаар шийдвэрлэнэ.
- 57.3. Хоршоог татан буулгасан тухай бүртгэх байгууллагад 7 хоногийн дотор мэдэгдэнэ.

58. Хоршоо татан буугдсаныг мэдэгдэх

- 55.1. Бүх гишүүдийн хурлаас хоршоог татан буулгасан тухай улсын бүртгэлийн байгууллагад 3 хоногийн дотор мэдэгдэнэ.
- 55.2. Татан буулгах комисс хоршоог татан буугдсаныг улсын бүртгэлд тэмдэглүүлсэн тухай нийтэд мэдээлнэ.
- 55.3. Хоршооноос авлагатай этгээдэд хоршоо татан буугдсан тухай тусгайлан мэдэгдэнэ.

59. Татан буулгах комисс томилох, эгүүлэн татах

- 59.1. Татан буулгах тухай шийдвэрийг бүх гишүүдийн хурал гаргасан бол татан буулгах комиссыг бүх гишүүдийн хурал томилно. Уг комисс татан буулгах ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.
- 59.2. Татан буулгах комиссыг бүх гишүүдийн хурал томилж чадаагүй бол Хяналтын зөвлөл, эсхүл Хоршоодын холбооны тэргүүлэгчид томилж болно.
- 59.3. Татан буулгах комиссын гишүүдийг бүртгэх байгууллагад мэдэгдэж холбогдох баримт бичгийг хүргүүлнэ.
- 59.4. Татан буулгах комисс нь хоршоо байсан аж ахуйн нэгжийн нэрийн хажууд „Татан буугдаж байгаа “ гэсэн бичилт хийж татан буулгах комиссын гишүүд нь гарын үсгээ зурна.
- 59.5. Шаардлагатай гэж үзвэл Татан буулгах комиссыг байгуулсан байгууллагын шийдвэрээр хугацаанаас нь өмнө эгүүлэн татаж болно.

60. Татан буулгах явцад гишүүдийн хоршоонд нийлүүлэх хувь хөрөнгийг нэмэгдүүлэх

- 60.1. Хоршоог татан буулгах явцад түүний нийт хөрөнгө нь өр төлбөр барагдуулахад хүрэлцэхгүй бол дутаж буй хэсгийг хоршоонд нийлүүлэх хувь хөрөнгөө дээд хэмжээнд нь хүртэл нийлүүлээгүй гишүүдэд хувь оногдуулах замаар гаргуулж нөхөн төлнө.

60.2. Хэрэв энэхүү дүрмийн 60.1. заасан гишүүдэд хувь оногдуулах замаар нэмэх өхөн төлбөр нь хүрэлцэхгүй бол өр төлбөрийг энэ дүрмийн 9.2-т заасан гишүүдийн нөхөх хариуцлагын хөрөнгөөр төлнө.

61. Хоршооны үйл ажиллагаа дуусгавар болсноос хойш гишүүдийн үүргийг нэмэгдүүлэхгүй байх

61.1. Хоршооны үйл ажиллагаа дуусгавар болсноос хойш гишүүдийн хоршоонд заавал нийлүүлэх хувь хөрөнгийн хэмжээ, нөхөх хариуцлагыг нэмэгдүүлж үл болно.

62. Хөрөнгө хуваарилахыг хориглох хугацаа

62.1. Хоршооны өр төлбөртэй холбоотой нэхэмжлэлийг Иргэний хуулийн 32 дугаар зүйлийн 5-дахь хэсгийн үндэслэн барагдуулна.

62.2. Хоршоонд нэхэмжлэл гаргах эрхтэй этгээд ийнхүү нэхэмжлэл гаргах боломжгүй нөхцөлд байгаа бол түүнд төлбөл зохих төлбөрийг нэгэн адил төлнө.

62.3. Төлбөрийн талаар маргаантай бол тухайн этгээдэд ногдох хэсгийг тусгаарласны дараа үлдсэн эд хөрөнгийг гишүүдэд хуваана.

63. Хоршооны эд хөрөнгийг гишүүдэд хуваарилах

63.1. Хоршооны харилцагчдын нэхэмжлэл хангах ажиллагаа дууссаны дараа Хоршооны тухай хуулийн 14, 16 дугаар зүйлийг үндэслэн гишүүдэд хоршооны үлдсэн эд хөрөнгийг хуваарилна.

63.2. Гишүүдийн эзэмших хувь хөрөнгийн хэмжээг хоршоог татан буулгалтын анхны тайлан мэдээг үндэслэн тогтооно.

63.3. Хоршооны гишүүн энэ дүрмийн 60.1, 60.2-ын дагуу нэмэлт хөрөнгө нийлүүлсэн бол эхлээд тэр хэмжээний хөрөнгийг түүнд олгоно.

63.4. Гишүүн нэг бүрт ногдох хувийг нь олгосны дараа хоршооны нийт хөрөнгөөс үлдсэн хэсгийг нийт гишүүдэдтэнцүү хэмжээгээр хуваана.

64. Хуваах боломжгүй үлдэгдэл хөрөнгө

64.1. Хоршооны үйл ажиллагаа дуусгавар болоход хуваах боломжгүй хөрөнгө үлдвэл шийдвэрлэх асуудлыг Татан буулгах комиссын саналаар бүх гишүүдийн хурлаас шийдвэрлэнэ.

61.2. Хөрөнгийг дуудлага худалдаанд оруулж мөнгөн орлогыг гишүүдэд хувь тэнцүүлэн хуваарилна.